| 93 | 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,502,100.00 | 5,760,621.00 | 741,479.00 | 88.6 |
| 94 | **81844 - ГҮНЗГИЙРҮҮЛСЭН БОЛОН ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТЫН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ** | | | | | |
| 94 | **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,200,100.00 | 3,200,100.00 | | 100 |
| 95 | 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,200,100.00 | 3,200,100.00 | | 100 |
| 96 | **81848 - СУРАХ БИЧГИЙН ТҮРЭЭС** | | | | | |
| 96 | **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 4,432,600.00 | -4,432,600.00 | |
| 97 | 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 4,432,600.00 | -4,432,600.00 | |
| 98 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | | | |
| 99 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | 29,473,045.18 | -29,473,045.18 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 100 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 66,849,988.34 | -66,849,988.34 | |

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын лаборатори сургууль нь бүрэн дунд боловсролын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд "Хүүхэд хөгжил, хамгааллын жишиг сургууль болох" гэсэн зорилт дэвшүүлж ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол,"Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоол, БШУС-ын 2023.06.13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1а/2714 албан бичгээр ЕБС, цэцэрлэгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх талаар ирүүлсэн чиглэл зэрэг тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагыг хянан баталж дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг цахимаар хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын лаборатори сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,958.5 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 29,473.0 | 66,849.9 | 37,376.9 |
| Авлага | - | - | - |
| Байгууллагаас авах авлага | 715.2 | 747.2 | 33,0 |
| Бараа материал | 51,317.0 | 59,602.1 | 8,285.1 |
| Үндсэн хөрөнгө | 1,639,650.4 | 1,688,235.5 | 48,585,1 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | (3,367,819.5) | (3,511,367.9) | (143,548.4) |
| **Нийт хөрөнгө** | **1,726,967.5** | **1,815,926.0** | **88,958.5** |
| Өр төлбөр | 2,214.3 | - | 2,214,3 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,724,753.1 | 1,815,926.0 | 91,172.9 |
| Өр төлбөр /богино хугацаат/ | | | |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,726,967.5** | **1,815,926.0** | **88,958.5** |

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансанд улсын төсвийн 66,849.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ. Цалин, НДШ-ийн зардлаас 48,132.8 мянга, хүүхдийн хоолны 3,483.2 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 8,285.1 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,688,235.5 мянган төгрөг болж 48,585.1 мянган төгрөгөөр өсчээ. БШУС-ын 2023 оны А/230 дугаар тушаалаар хуваарилсан 35,080.0 мянган төгрөгийн нөхөн хангалтын зардлын санхүүжилтээс 31,145.3 мянган төгрөгөөр сургалтын тоног төхөөрөмжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжид нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллажээ. Мөн БШУЯ-аас 107,453.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж,тавилга эд хогшил, аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 98,060.0 мянган төгрөгийн сангийн их засвар шилжүүлэн авсан, хандиваар 5,940.30 мянган төгрөгний 2 ш зөөврийн компютер, дахин үнэлгээгээр 38,024,.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн нь үндсэн хөрөнгө нэмэгдэхэд нөлөөлсөн. Мөн 49,298.9 мянган төгрөгний хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Тайлант хугацаанд 246,102.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,815,926.0 мянган төгрөг болж 91,172.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт орлого өмнөх оноос 526,401.6 мянган төгрөгөөр буюу 27.1 хувиар өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө өмнөх оноос 143,111.9 мянган төгрөгөөр өсч , санхүүжилтийн орлого 376,879.7 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 6,410.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Урсгал зардал өмнөх оноос 490,540.0 мянган төгрөгөөр өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 314,213.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 61,895.5 мянга, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол 107,249.8 мянга, хоол, хүнсний зардал 2,670.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

**Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2023 оны төсвийг 1,869,540.6 төгрөгөөр баталсныг тайлант онд 2 удаа өөрчлөлт оруулж, тодотгон оны эцэст 1,832,585.3 мянган төгрөгөөр буюу 36,955.3 мянган төгрөгөөр бууруулжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,832,585.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 355,116.7 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,832,585.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 66,850.0 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,158,145.5 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 43,623.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,510.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,954.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна. Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хүүхдийн хоолны зарцуулагдаагүй үлдэгдлээс 6,252.8 мянган төгрөгөөр “Ахмадын сан” байгуулсан байна.

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| Хөтөлбөр | д/д | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| **71802 Ерөнхий боловсрол** | 1 | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ | 3,470.9 | 3,470.9 | 0 | 100 |
| | 2 | 80312- Сургалт семинар | 1,735.4 | 1,735.3 | (38.0) | 99.9 |
| | 3 | 81605- Эрүүл мэндийг дэмжих | 3,470.9 | 3,470.9 | - | 100 |
| | 4 | 81801- Үдийн цай хөтөлбөр | 68,708.2 | 55,004.8 | 13,703.4 | 80.06 |
| | 5 | 81806-Дотуур байрны хүүхдийн хоол | 60,040.1 | 56,556.9 | 3,483.2 | 94.2 |
| | 6 | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 35,080.0 | 35,080.0 | 0 | 100.0 |
| | 7 | 81823- Боловсролын багшийн сургалт | 7,809.5 | 7,809.5 | 0 | 100 |
| | 8 | 81834- Боловсролын стандарт сургалт | 1,242,200.8 | 1,216,437.1 | 35,058.8 | 98.7 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 9 | 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 365,743.7 | 360,699.5 | 5,044.2 | 98,3 |
| | 10 | 81848 – гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтйн орчин | 3,200.1 | 3,200.1 | 0 | 100 |
| | 11 | 81848-Сурах бичгийн түрээс | 4,432.6 | 4,432.6 | - | 100.0 |
| | 12 | 80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 355,116.7 | 350,162.5 | 4,954.2 | 74.35 |
| | | | | | | |
| **Нийт** | | | **2,219,032.9** | **2,158,145.5** | **60,887.4** | **97.26** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын лаборатори сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "ЦЭСБ аудит" ХХК-ийн ахлах аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Д.Туяа нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын лаборатори сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,883,507.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,835.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын дүнгээс 70 хувиар

тооцон 13,184.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

тогтоосныг гүйцэтгэх үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Энэ хуулийн хүрээнд батлагдсан төсөв 66,850.0 мянган төгрөгөөр зарцуулагдаагүй үлдсэн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 43,623.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,510.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,954.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтуудтай холбоотой зардлыг санхүүжүүлээгүй байна. Төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж сургалт зохион байгуулсан нь хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтыг зөрчсөн байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын лаборатори сургуулийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын зарцуулалт, төсвийн зарцуулалттай холбоотой асуудлыг хянахаар тусгайлан авч үзсэн. Аудитаар олимпиад, уралдаан тэмцээнийг ивээн тэтгэсэн, хүүхдийн хоолны зарцуулагдаагүй үлдэгдлээс ахмадын сан байгуулсан зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу 14,388.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 1 | 14,388.1 | 1 | 14,388.1 | 100 |
| **Нийт дүн** | 1 | 14,388.1 | 1 | 14,388.1 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 2,190.8 мянган төгрөгийн алдааг залруулж, нийт 12,510.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,251.5 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 9,258.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1.Сургуулийн ажилтнууд оролцсон спортын уралдаан тэмцээний бооцоонд 100.0 төгрөг хандивласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн “Хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалт” гэсэн 2 дугаар бүлгийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “*Хуулиар зөвшөөрөөгүй бусад*” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.1-т ”төрийн өмч, хөрөнгийг үндэслэлгүйгээр бусдад хандивласан, үнэ төлбөргүй шилжүүлсэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

2. Сургуулийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэсэн сургалтын менежер Ч. Алимаагийн үндсэн цалинг буруу тогтоож 1,044.6 мянган төгрөг илүү олгосон нь Төрийн албаны тухай тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох” журмын 2.2-т “Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэж байгаа хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн албан хаагчид олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

3. Дотуур байрны жижүүрүүдэд анхан шатны баримтгүй, үндэслэлгүйгээр  394.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс нэмж олгосон зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн

тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Иймд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т ”цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

4. Багш ажилтнуудад үндэслэх баримтгүйгээр 1,712.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл давхардуулж олгосон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4.3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т ”*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

**5.2 Албан шаардлага**

1. Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж, 1,815.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“*Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”,* БШУС, Эрүүл мэндийн сайдын 2022 оны хамтарсан А/328, 1/340 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах“ тухай журмын 1-д заасан “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалт”-*ыг* зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

2. Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хүүхдийн хоолны зарцуулагдаагүй үлдэгдлээс 6,252.8 мянган төгрөгөөр “Ахмадын сан” байгуулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт ”Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3-т “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэж заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.8-д ”Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

3. Төрийн бус байгууллагтай 1,190.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулж сургалт зохион байгуулсан ч үр дүнг тайлагнаагүй, гэрээг дүгнээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“*Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”,* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т *“*сургалт, семинар, хурал,

зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.8-д ”Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

**5.3 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй байна.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | Үнэээс | | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | | |
| | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Авлага, бараа материалын үлдэгдэл нэмэгдэж бараа үйлчилгээний зардал буурсан. | 1 | 2.190.8 | | | 1 2,190.8 | 1 | 2,190.8 | | | | | |
| Дүн | 1 | 2,190.8 | - | - | 1 2,190.8 | 1 | 2,190.8 | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сургуулийн ажилтнууд оролцсон спортын уралдаан тэмцээний бооцоонд Спортын уралдаан тэмцээний бооцоонд хөрөнгө хандивласан | 1 | 100.0 | 1 | 100.0 | | | | | | | | |
| Сургуулийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэсэн сургалтын менежер Ч. Алимаагийн үндсэн цалинг буруу тооцож, олгосон. | 1 | 1,044.6 | 1 | 1,044.6 | | | | | | | | |
| Дотуур байрны жижүүрүүдэд анхан шатны баримтгүй, үндэслэлгүйгээр илүү цагийн хөлс нэмж олгосон | 1 | 394.4 | 1 | 394.4 | | | | | | | | |
| Багш ажилтнуудад үндэслэх баримтгүйгээр ур чадварын нэмэгдэл давхардуулж олгосон. | 1 | 1,712.5 | 1 | 1,712.5 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж төлбөр төлсөн. | 1 | 1,815.9 | | | 1 | 1,815.9 | | | | | | |
| Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хүүхдийн хоолны зарцуулагдаагүй үлдэгдлээс “Ахмадын сан” байгуулсан. | 1 | 6,252.8 | | | 1 | 6,252.8 | | | | | | |
| Дүн | 6 | 11,320.2 | 4 | 3,251.5 | 2 | 8,068.7 | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төрийн бус байгууллагтай гэрээ байгуулж сургалт зохион байгуулсан ч үр дүнг тайлагнаагүй, гэрээг дүгнээгүй. | 1 | 1,190.0 | | | 1 | 1,190.0 | | |
| Дүн | 1 | 1,190.0 | | | 1 | 1,190.0 | | |
| Нийт дүн | 1 | 1,190.0 | - | - | 1 | 1,190.0 | | |